

Батлав. ХГ-ын дарга



Д.Чинзориг

Батлав. Улсын бүртгэлийн хэлтэс-ийн Дарга



Л.Цэлмэг

### ЗАР ЯВУУЛАХ ГЭРЭЭ

2015 оны 4-р сарын 01

№

Чойр хот.

#### 1. Нийтлэг үндэслэл

1.1 Орон нутгийн ард иргэдэд Байгууллага, сурталчилан таниулах үйлчилгээний талаарх мэдээллийг шуурхай мэдээлэх зорилгоор энэхүү гэрээг аймгийн Холбооны газар нөгөө талаас УБХэлтэс хамтарч доорх нөхцөлтэйгээр гэрээ байгуулав.

1.2 Энэхүү гэрээ нь 2015 оны 04 -р сарын-01-ны өдрөөс, 2015 оны 12-р сарын 31 -ны өдрийг дуусталх хугацаанд үйлчилнэ.

#### 2. Улсын бүртгэлийн хэлтсийн хүлээх үүрэг

2.1 Тухайн гэрээ байгуулсан өдрөөс УБХэлтэс нь шаардлага хангасан материал бэлтгэж өгөх

2.2 Мэдээллийг хувь хүний болон өөр байгууллагын эрх ашигт харшлахгүйгээр бэлтгэж албан тоотой тодорхой албан тушаалтны гарын үсэг, тамга тэмдэгээр баталгаажуулж өгнө. / Албан тоот дээр зарын явуулах хугацааг зааж өгөх/

2.3 УБХэлтэс нь зарын мэдээллийг бэлтгэж өгнө.  
2. Сар бүрийн 25-ны дотор сарын төлбөр болох 100000 / Нэг зуун мянган/ НӨАТ Нэмэгдэнэ / төгрөгийг ХААН банкны **5990054972** тоот дансанд нэхэмжлэлийн дагуу төлнө.

#### 3. Холбооны газрын хүлээх үүрэг

3.1 Холбооны газар нь УБХэлтэс-ийн бэлтгэж өгсөн мэдээллийг зарын сувгаар нэвтрүүлж өгнө.

3.2 Яаралтай онц шаардлагатай нөхцөлд графикт хугацаанаас хамаарахгүй мэдээллийг дамжуулна.

#### 4. Нэмэлт заалт

4.1 Үнэ тарифийн ханш өөрчлөгдөх, холбооны газрын техник тоног төхөөрөмжинд өөрчлөлт гарах, үйл ажиллагааны хүрээ нэмэгдэх үед талууд гэрээг шинэчилнэ.

4.2 УБХэлтэс-ийн бэлтгэж өгсөн зарын найруулгын алдааг Холбооны газар хариуцахгүй.

Гэрээ байгуулсан:

Холбооны газрын Ахлах-ня-бо

УБХэ-ийн Нягтлан бодогч





Б.Алтанцэцэг /...../

П.Батцэцэг /...../

Утас: 70543144,

Утас : 70543888

Батлав:  "Алхана трейд" ХХК-ийн Говьсүмбэр  
Аймаг дахь салбарын  
дарга  /О.Энх-Эрдэнэ/

Батлав:    
Дарга   
№ 

### ТАЛОНООР ШАТАХУУН НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ /БАЙГУУЛЛАГА/

2016 оны 11 сарын 11 өдөр

Чойр

Нэг талаас нефтийн бүтээгдэхүүн импортлогч "Алхана трейд" ХХК-ийг төлөөлж нягтлан бодогч О.Энх-Эрдэнэ (цаашид Нийлүүлэгч гэх), нөгөө талаас У.Бадамтэс төлөөлж На-во албан тушаалтай Ч.Монголсайч (цаашид үйлчлүүлэгч байгууллага гэх) нар харилцан тохиролцож, энэхүү гэрээг байгуулав.

Энэхүү гэрээний зорилго нь тус үйлчлүүлэгч байгууллага болон ШТС-ийн үйлчилгээг түргэн шуурхай, найдвартай тасралтгүй үзүүлэхэд оршино.

#### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Нийлүүлэгчээс олгосон шатахууны талон нь зөвхөн шатахуун худалдан авахад зориулагдсан болно.
- 1.2 Шатахуун түгээх талоныг урьдчилан худалдаж авах нь "Сод монгол Групп" ХХК-ийн аль ч салбар ШТС-аар талоны үнийн дүнтэй тэнцэх шатахуунаар үйлчлүүлэх үндэслэл болно.
- 1.3 Худалдан авагч тал нь өөрийн ажил үйлчилгээний хэрэгцээнд сард.....литр шатахууныг зээлийн нөхцлөөр авна.
- 1.4 Нийлүүлэгч тал нь шатахууны талоноор тухайн үеийн зах зээлийн тухайн ШТС-ын жижиглэнгийн жишиг үнээр шатахуун нийлүүлэх үйлчилгээ үзүүлнэ. Үнийн дүнд НӨАТ тооцсон байна.
- 1.5 Талууд энэхүү гэрээгээ хүндэтгэн үзэж, гэрээнд дурдсан ажил үйлчилгээг бусад төрлийн байгууллагаас авахгүй байхыг эрхэмлэнэ.

#### Хоёр. Гэрээний хугацаа

- 2.1 Энэхүү гэрээ нь 2016 оны 01 -р сарын 01 -аас 2016 оны 12 -р сарын 31 -ны өдрийг дуустал хугацаанд хүчинтэй байна.
- 2.2 Гэрээний 2.1 дэх хэсэгт заасан хугацаа дуусгавар болоход талуудын аль нэг нь гэрээг дуусгавар болгох санал тавиагүй бол Гэрээг энэхүү гэнээнд заасан нөхцлөөр дахин нэг жилээр сунгасанд тооцно

### Зургаа. Гэрээ цуцлах, дуусгавар болгох нөхцөл

6.1 Дараах тохиолдолд гэрээ дуусгавар болно. Үүнд:

6.1.1 Гэрээний хугацаа дуусаж гэрээний биелэлтийг дүгнэснээр

6.1.2 Талууд харилцан тохиролцсоноор

6.1.3 Аль нэг тал гэрээнд заасан нөхцлүүдийг удаа дараа биелүүлээгүй, зөрчсөн нөхцөлд

### Долоо. Бусад зүйл

7.1 Гэрээтэй холбогдон үүсэн гарах маргааныг талууд эвийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд тохиролцож чадаагүй тохиолдолд шүүхээр шийдвэрлүүлнэ.

7.2 Энэ гэрээний бүх нөхцөл, заалтыг эрх бүхий албан тушаалтнууд зөвшөөрснөөр 2 хувь үйлдэн гарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

7.3 Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр энэхүү гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд нэмэлт өөрчлөлтийг бичгээр үйлдэн хүчин төгөлдөр болсноор гэрээний салшгүй нэг хэсэг болно.

7.4 Гэрээний хугацаа дууссан тохиолдолд худалдан авагч талын албан ёсны хүсэлтээр гэрээг сунгаж болно.

7.5 Энэхүү гэрээнд заагдсан хугацааг хуанлийн хоногоор тоолно.

7.6 Энэхүү гэрээтэй холбогдох баримт бичиг, бүх хавсралтууд нь гэрээний салшгүй хэсэг болох ба эдгээр нь адил хүчинтэй хоёр хувь үйлдэгдэж, тал тус бүрт нэг хувь хадгалагдана.

### Талуудын албан ёсны хаяг

Худалдагч тал:	
Хаяг: Говьсүмбэр аймаг Сүмбэр сум 1-р баг	
Утас: 88208293, 99984823	
Факс: 0254240440, 0254240441	
И-мэйл хаяг:	

### Гэрээ байгуулсан:

Худалдагч талыг төлөөлж:

“Алхана трейд” ХХК –ийн

Нягтлан бодогч

/О.Энх-Эрдэнэ/

Худалдан авагч талыг төлөөлж:

Ня-бо

Гэрээний дугаар  
FP/CP - 052

**ФИНПАК**  
ЦААС, ЦААСАН БҮТЭЭГДЭХҮҮН

Батлав. "Финпак" ХХК-ийн  
Гүйцэтгэх захирал

...../Б.Цасчимэг/



Батлав. "....."  
..... захирал

Handwritten signature and date 26.09.2016 over a red rectangular stamp.

## ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

Энэхүү гэрээг нэг талаас Улаанбаатар хот Баянгол дүүрэг, 20-р хороо "Азия пропертийс" ХХК-ийн байр "Финпак" ХХК /Улсын бүртгэлийн дугаар:9019003051/-ийг төлөөлж Борлуулалтын менежер Дамдин овогтой Баярцогт цаашид "Худалдагч тал" гэх), нөгөө талаас Г.С.А. Гүндүр З.ДТ хаягт орших Дорнод улсын бүртгэлийн дугаартай "....." ХХК-ийг төлөөлж тус компанид Дорнод улсын бүртгэлийн дугаартай ..... ажилтай ..... овогтой ..... (цаашид "Худалдан авагч тал" гэх) нар харилцан тохиролцож дараах нөхцөлтэйгээр байгуулав.

### Нэг. Ерөнхий зүйл

- 1.1 Уг гэрээний гол зорилго нь гэрээгээр тохирсон нөхцлийн дагуу худалдагч талаас худалдан авагч талд чанар, стандартын шаардлага хангасан
- А3, А4 форматын 70, 75, 80, 90, 100 гр/м<sup>2</sup> бичгийн цаас,
  - А, В форматын хуудсаарх болон рулонтай хэвлэлийн цаас, будаг, хавтан,
  - Сурагчийн, Оюутны, Тэмдэглэлийн дэвтэр,
  - Санхүүгийн маягтууд, Архивын хавтас,
  - Баримтын хайрцаг, дугтуй, термал цаас, аюулгүйн хайрцаг
  - Цаасан хайрцаг, Цаасан уут, Тор,
  - Цаасан алчуур, сальфетка болон бусад цаасан бүтээгдэхүүн
- /гэрээгээр тохирсон барааг доогуур нь зурах/ /цаашид "бараа" гэх/-г захиалгын дагуу зээлээр нийлүүлэх, худалдан авагч тал гэрээнд заасан хугацаанд барааны төлбөрийг төлөхтэй холбогдон үүссэн харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Талууд гэрээнд тусгагдаагүй асуудлыг шийдвэрлэхдээ Монгол Улсын Иргэний хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг мөрдлөг болгоно.

### Хоёр. Бараа нийлүүлэх нөхцөл, үнэ

- 2.1 Худалдан авагч тал биечлэн болон итгэмжлэгдсэн ажилтнаараа дамжуулан барааны нэр төрөл, чанар, стандартын шаардлагатай урьдчилан танилцаж, тохиролцсон нөхцлөөр гэрээний дагуу худалдагч тал барааг нийлүүлнэ.
- 2.2 Худалдагч тал барааг худалдан авагч талд шилжүүлэн өгснөөр энэхүү гэрээний дагуу барааг нийлүүлсэнд тооцно.
- 2.3 Худалдан авагч тал тухайн сар, улиралд худалдан авах барааны ерөнхий тоо хэмжээ, нэр төрлийг жагсаалтаар тухайн улирал эхлэхийн өмнөх сарын 20-ны дотор худалдагч талд гаргаж өгнө.
- 2.4 Худалдагч тал нь худалдан авагч талаас гэнэтийн захиалга хүлээн авснаас хойш ажлын 10 хоногийн дотор нийлүүлэх боломж, хугацаа, үнийн талаар хариу мэдэгдэж, захиалгыг албан ёсоор баталгаажуулна.
- 2.5 Барааны нэг бүрийн үнийг өртөгт шингэх зардал, зах зээлийн нөхцөл, эрэлт, нийлүүлэлтийн харьцааг харгалзан худалдагч тал тогтооно. Үнэнд НӨАТ орсон байна.
- 2.6 Гэрээ хүчин төгөлдөр үйлчлэх хугацаанд барааны үнийг зах зээлийн үнийн хэлбэлзэл, борлуулалтын байдлыг харгалзан худалдагч тал өөрчлөх эрхтэй ба үнийн өөрчлөлтийн тухай худалдан авагч талд ажлын 3 хоногийн дотор албан ёсоор мэдэгдэнэ. /Үүнд: валютын ханшны өөрчлөлттэй уялдуулан үнэ өөрчлөгдөх, нийлүүлэгчдээс үнэ нэмэгдэж ирэх г.м /

Худалдах, худалдан  
авах гэрээ

Хуудас 1 - 5

Улаанбаатар хот  
2016-01-02

### Гурав. Худалдагч талын эрх, үүрэг

- 3.1 Худалдагч тал барааг захиалгын дагуу худалдан авагч талд нийлүүлэх үүрэг хүлээх ба хүлээлгэн өгөх хүртэл түүний чанар, өнгө үзэмж, бүрэн бүтэн байдлыг хариуцна.
- 3.2 Энэ гэрээний 3.2-т заасан дагуу барааг худалдан авагч талд шилжүүлэх үед доголдол илэрвэл адил нэр төрлийн зохих чанарын бараагаар солих үүрэгтэй.
- 3.3 Худалдагч тал нь худалдан авагч талын захиалсан 300 000 төгрөгнөөс дээш /Их тойруугаас гадагш зайд 300 000 төгрөгөөс дээш/ үнийн дүнтэй барааг өөрийн унаагаар хүргэж өгөх үүрэгтэй.
- 3.4 Худалдагч тал нь худалдан авагч талаас ажлын өдөр 12.00 цагаас өмнө хүлээн авсан бараа захиалгыг тухайн өдөрт нь, 12.01 цагаас хойш өгсөн захиалгыг дараа өдөрт нь хүргэж худалдан авагч талын итгэмжлэгдсэн ажилтанд хүлээлгэж өгнө.
- 3.5 Худалдан авагч тал гэнэтийн захиалгаа урьдчилж өгөн баталгаажуулаагүйгээс нийлүүлэлт тасалдахад хүрснээс гарсан хохирлыг худалдагч тал хариуцахгүй.
- 3.6 Худалдагч талын худалдан авагч талд өгсөн захиалга нь тухайн үед биелэгдэх боломжгүй тохиолдолд /цаасны нөөц дууссан, гэнэтийн аваар осол гэх мэт/ энэ талаар худалдан авагч талд нэг цагийн дотор мэдэгдэнэ.
- 3.7 Худалдагч тал худалдан авагч талын хүлээн авсан барааны дагуу санхүүгийн баримт үйлдэж, тамга, гарын үсгээр баталгаажуулан, итгэмжлэгдсэн ажилтанд хүлээлгэж өгнө.
- 3.8 Худалдагч тал нь худалдан авагч талын хэвлэлтэй холбоотой хохирлыг хариуцахгүй.
- 3.9 Худалдагч тал нь худалдан авагч талаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг болон барааны үнийг төлөхийг шаардах эрхтэй.

### Дөрөв. Худалдан авагч талын эрх, үүрэг

- 4.1 Худалдан авагч тал нь худалдагч талд захиалгаа албан бичгээр болон **99904028 99904018** тоот утсаар өгөх ба албан ёсоор захиалсан тоо, хэмжээ бүхий барааг захиалсан хугацаандаа бүрэн хүлээн авч, төлбөрийг гэрээний хугацаанд төлөх үүрэгтэй.
- 4.2 Худалдан авагч тал нь өөрийн итгэмжлэгдсэн ажилтнаар дамжуулан хүргэгдэж ирсэн барааны тоо ширхэг, чанар, иж бүрдлийг сайтар шалган авч, хүлээн зөвшөөрсний үндсэн дээр дагалдах баримттай нь тулгаж, баталгаажуулан хурдан шуурхай хүлээж авах үүрэгтэй.
- 4.3 Худалдан авагч тал нь худалдагч талын болон барааны бизнесийн нэр хүндэд сөргөөр нөлөөлөх үйлдэл гаргахгүй байх үүрэгтэй.
- 4.4 Худалдан авагч тал нь худалдагч талаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах эрхтэй.
- 4.5 Худалдан авагч тал нь зохих чанар, стандартын шаардлага хангасан бараа нийлүүлэхийг буюу барааг хүлээн авах үед илэрсэн доголдлыг арилгахыг шаардах эрхтэй.
- 4.6 Худалдагч талаас захиалга, төлбөр төлөлтийн байдалд хяналт тавьж, тооцоо нийлэх боломжоор хангах үүрэгтэй.
- 4.7 Гэрээ байгуулах болон сунгахдаа худалдагч талын шаардсан баримт бичгийг энэхүү гэрээг дагалдах баримт болгон өгөх үүрэгтэй. Үүнд: компанийн улсын бүртгэлийн гэрчилгээний наториатаар баталгаажсан хуулбар, гэрээ байгуулах эрх бүхий этгээдийн болон худалдагч талтай биечлэн хамтран ажиллах итгэмжлэгдсэн ажилтны товч анкет, тодорхойлолт, гарын үсгийн баталгаа
- 4.8 Барааны тухай санал, гомдлыг худалдагч талын итгэмжлэгдсэн ажилтанд 24 цагийн дотор мэдэгдэж шийдвэрлүүлнэ. Уг хугацаанд шийдвэрлүүлээгүй хугацаа хэтэрсэн тохиолдолд холбогдох санал гомдлыг худалдагч тал хүлээн авахгүй болно.
- 4.9 Барааг худалдан авагч талд хүргэж хүлээлгэн өгснөөр бараатай холбогдох эрх худалдан авагч талд бүрэн шилжиж, барааг гэмтээх, норгох, механик гэмтэл учруулах, хадгалалтын горим зөрчих, чанарыг алдагдуулах зэргээс учирсан хохирлыг худалдан авагч тал бүрэн хариуцна.

### Тав. Төлбөр тооцоо

- 5.1 Худалдагч тал нь худалдан авагч талд барааг зээлээр: /харилцан тохирсон нөхцлийн доогуур зур/  
**а/ падаанаас падааны хооронд**

б/ 14 /арвандөрөв/ хоногийн циклээр  
в/ 1 сарын циклээр  
г/ холбогдох тооцоог сард нэг удаа тэглэх

- заалтаас ...-ыг сонгон, зээлээр олгох барааны үнийн дүн .....1 000 000..... /тоогоор/,  
.....нэг сая төгрөг..... /үсгээр/ төгрөгөөс илүүгүй  
байхаар тохиролцов.
- 5.2 Энэхүү цикл сар бүрийн ...../25/ хорин тавны.....-ны өдрийн хооронд  
үргэлжилнэ. Нэг циклд худалдан авах бараа нь тогтсон лимитээс хэтрэх тохиолдолд илүү  
гарсан төлбөрийг бэлнээр эсвэл дансаар худалдагч талд шилжүүлнэ.
- 5.3 Талуудын хоорондын төлбөр тооцоог харилцагч талуудын санхүүгийн газар хариуцан  
гүйцэтгэнэ.
- 5.4 Худалдагч тал нь төлбөрийг сар бүрийн ..... -ны өдрөөр тасалбар болгон нэхэмжилж,  
худалдан авагч тал нь зээлээр авсан барааны төлбөрийг тасалбар болгосон өдрөөс хойш  
ажлын 5 хоногт бүрэн барагдуулна. Өөрөөр хэлбэл тухайн өдрүүдэд өр авлага бүрэн  
тэглэсэн үед дахин бараа зээлээр худалдан авах эрх үүснэ.
- 5.5 Худалдан авагч тал бэлнээр төлбөр хийх үед худалдагч талын итгэмжлэгдсэн ажилтанд  
холбогдох баримт үйлдэн тооцоо хийж, энэ тухайгаа худалдагч талын санхүүд 7577-0333  
тоот утсаар мэдэгдэнэ.
- 5.6 Худалдан авагч тал төлбөрийг дансаар шилжүүлсэн тохиолдолд худалдагч талд нэн даруй  
утсаар мэдэгдэн баримтын эх хувийг буюу хуулбарыг факсаар ирүүлсэнээр төлбөр  
төлөгдсөнд тооцогдоно.
- 5.7 Худалдан авагчийн агуулахад барааны үлдэгдэлтэй байх эсэхээс үл хамааран худалдан авагч  
нь гэрээний хугацаанд барааны төлбөрийг бүрэн төлж барагдуулна.
- 5.8 Худалдан авагч тал төлбөр төлөх хугацаа хожимдуулсан болон зээлийн төлбөрийг тэглэх  
хугацааг хэтрүүлсэн хоног тутам гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнд, 0,1 хувийн алданги  
худалдагч талд төлнө.
- 5.9 Гэрээнд заасан хугацаанд төлбөрийг төлөөгүй буюу тэглээгүй тохиолдолд зээлээр болон  
бэлэн мөнгөөр борлуулалт хийгдэхгүй бөгөөд үүнээс үүдэн гарах хохирлыг худалдагч тал  
хариуцахгүй ба худалдагч тал дангаар гэрээг цуцлах эрхтэй.
- 5.10 Тооцооны үлдэгдлийг сар бүр төлбөр төлөгдөх бөгөөд тооцоо зөрсөн тохиолдолд хоёр  
борлуулалтын нягтлан бодогчтой утсаар нийлэх бөгөөд тооцоо зөрсөн тохиолдолд хоёр  
талын нягтлан бодогчид биечлэн тооцоо нийлнэ. Тооцоо нийлсэн тухай актыг улирал  
бүрийн дараа сарын эхний 15 хоногт багтаан хийж 2 тал гарын үсэг зурж тамга, тэмдэгээр  
баталгаажуулан хадгална.

### Зургаа. Талуудын хариуцлага

- 6.1 Талуудын аль нэг нь хуулийн этгээдийн хувьд өөрчлөгдсөн боловч үйл ажиллагааны чиглэл  
хэвээр байх тохиолдолд гэрээ цуцлагдахгүй ба гэрээг шинэчлэн байгуулна.
- 6.2 Гэрээний хэрэгжилтийн явцад гарсан аливаа маргааныг хоёр тал харилцан зөвшилцөх  
замаар шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд тохиролцоонд эс хүрвэл холбогдох хуулийн дагуу  
шүүхээр шийдвэрлүүлнэ.
- 6.3 Маргааныг шүүхээр шийдвэрлүүлэхтэй холбогдон гарсан аливаа зардлыг /шүүх,  
өмгөөлөгчийн зардал гэх мэт/ буруутай тал бүрэн хариуцна.
- 6.4 Худалдан авагч тал төлбөр төлөх гэрээний заалтыг зөрчсөн тохиолдолд худалдагч тал  
дараах хариуцлагыг тооцно. Үүнд:
- 6.4.1 гэрээний дагуу төлөх төлбөрийн хугацааг 7 хоног хэтрүүлбэл санхүүгийн газраас алданги  
тооцож эхэлсэн тухай албан тоот явуулах
- 6.4.2 14 хоног хэтрүүлбэл хуулийн зөвлөхөөс мэдэгдэл явуулах
- 6.4.3 21 хоног хэтрүүлбэл ерөнхий захирлын албан тоот явуулах
- 6.4.4 45 хоног хэтрүүлбэл холбогдох хуулийн дагуу шүүхэд хандан асуудлыг шийдвэрлүүлнэ.
- 6.5 Төлбөр бүрэн төлөгдтөл худалдан авагч талын гэрээний үүрэг хэвээр хадгалагдана.
- 6.6 Гэрээг хүчин төгөлдөр хугацаанаас нь өмнө цуцлахыг хүссэн тал нөгөө талд уг хүсэлтээ  
албан ёсоор бичгээр 14 хоногийн өмнө мэдэгдэж, харилцан зөвшилцсөнөөр гэрээг дүгнэн  
акт үйлдэж цуцлана.

- 6.7 Худалдан авагч тал төлбөрийг хугацаанд нь барагдуулаагүйгээс /зээлээр худалдан авсан барааны төлбөрийг ажлын 3-аас илүү хоног 3-аас дээш удаа хэтрүүлсэн тохиолдолд/ худалдагч талын санаачлагаар гэрээг цуцлах тохиолдолд худалдагч талаас худалдан авагч талд албан бичгээр мэдэгдсэн өдрөөс эхлэн гэрээ цуцлагдсанд тооцно.
- 6.8 Талууд гэрээний дагуу хүлээх үүрэг, хариуцлагаа гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.

#### Долоо. Давагдашгүй хүчин зүйл

- 7.1 Давагдашгүй хүчин зүйл /үер, гал түймэр, газар хөдлөлт, халдварт өвчний хорио, зэвсэгт мөргөлдөөн, террорист үйлдэл, иргэдийн үймээн, ажил хаялт, төрийн шийдвэр, оролцоо гэх мэт/-ийн нөхцөл байдлын шууд болон шууд бус үйлчлэлийн улмаас талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй тохиолдолд гэрээний үйлчлэх хугацааг тухайн нөхцөл байдлыг арилах хүртэл хойшлуулж болно.
- 7.2 Гэрээний үүргийг биелүүлэхэд саад болох нөхцөл байдал үүссэн, дууссан тухай бүр талууд нэг нэгэндээ албан бичгээр нэн даруй мэдэгдэнэ.
- 7.3 Тухайн нөхцөл байдлын улмаас гэрээний үүргийн хугацаа 30 хоногоор хойшлогдвол талуудын аль нэг нь гэрээг цуцлах санал гаргаж болох ба гэрээгээр хүлээсэн үүрэг хэвээр хадгалагдана.

#### Найм. Бусад зүйл

- 8.1 Энэхүү гэрээ нь талууд харилцан зөвшилцөж гарын үсэг зуран, тамга тэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчлэх ба уг гэрээний хавсралт нь түүний салшгүй хэсэг байна.
- 8.2 Гэрээг Монгол хэлээр 3 хувь үйлдэж, худалдагч тал 2 хувийг, худалдан авагч тал 1 хувийг тус тус хадгалан, дагаж мөрдөнө.
- 8.3 Гэрээний ерөнхий хугацаа 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2017 оны 02 дугаар сарын 01-ний өдөр хүртэл хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 8.4 Талууд харилцан тохиролцсон тохиолдолд гэрээг тодорхой хугацаагаар сунгаж болно. Гэрээг сунгах санал гаргагч тал 8.3-т заасан хугацаа дуусгавар болохоос 30 хоногийн өмнө албан бичгээр нөгөө талд мэдэгдэнэ.
- 8.5 Гэрээний үйлчлэх хугацааг дараах тохиолдолд хугацаанаас нь өмнө цуцлаж болно.
- талуудын зөвшилцсөнөөр
  - төлбөрийг хугацаанд нь барагдуулаагүйгээс худалдагч талын санаачлагаар
  - эрх бүхий байгууллагын шийдвэрээр
  - давагдашгүй хүчин зүйлийн улмаас
- 8.6 Гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах тохиолдолд санаачлагч тал энэ тухай нөгөө талд 14 хоногийн өмнө бичгээр албан ёсоор мэдэгдэж, хоёр тал харилцан гэрээг дүгнэн, холбогдох акт үйлдэн гэрээг цуцлана.
- 8.7 Талуудын харилцан зөвшилцлийн үндсэн дээр гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болно. Нэмэлт өөрчлөлт оруулсан хавсралтыг гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулан, үндсэн гэрээнд хавсаргана.

#### ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Худалдагч талыг төлөөлж,  
Борлуулалтын менежер  
... /Д.Баярцогт/  
Хаяг: "Финпак" ХХК  
Баянгол дүүрэг 20-р хороо Азия пропертиз байр  
Утас: 7577-0555, 99904028 99904018  
Факс: 7577-0888  
Е-мэйл: order@finpack.mn  
www.finpack.mn  
Харилцах данс:  
Голомт банк -1102047667 /төг/  
Худалдаа Хөгжлийн Банк- 499041958 /төг/  
ХААН банк – 5032371358 /төг/

Худалдан авагч талыг төлөөлж,  
... ажилтай  
Хаяг: ...  
Утас: ...  
Факс: ...  
Е-мэйл: ...  
Харилцах данс:  
...  
...

Гэрээний дугаар  
FP/CP - 052



Батлав. "Финпак" ХХК-ийн  
Гүйцэтгэх захирал  
..... /Б. Цасчимэг/



### ХАВСРАЛТ № 1

### ИТГЭМЖЛЭГДСЭН АЖИЛТНЫ ГАРЫН ҮСГИЙН БАТАЛГАА

Энэхүү хуудсанд "Финпак" ХХК-ийн

- *A3, A4* форматын *70, 80, 90, 100* гр/м<sup>2</sup> бичгийн цаас,
- *A, B* форматын хуудсаарх болон рулонтай хэвлэлийн цаас, будаг, хавтан,
- Сурагчийн, Оюутны, Тэмдэглэлийн дэвтэр,
- Санхүүгийн маягтууд, Архивын хавтас,
- Баримтын хайрцаг, дугуй,
- Цаасан хайрцаг, Цаасан уут, Тор, аюулгүйн хайрцаг
- Цаасан алчуур, сальфетка болон бусад цаасан бүтээгдэхүүн

/гэрээгээр тохирсон барааг доогуур нь зурах/ /цаашид "бараа" гэх/ хүлээн авах, захиалга өгөх, төлбөр тооцоог шилжүүлэх ажилтны албан тушаал, гарын үсгийн баталгаа, утасны жагсаалтыг баталгаажуулав.

Итгэмжлэгдсэн ажилтны овог нэр, регистрийн дугаар	Албан тушаал	Гарын үсэг	Утасны дугаар
<i>Луудраа Цэцэг</i> <i>23 8103 1912</i>	<i>Дорно</i>	<i>[Signature]</i>	<i>99002438,</i>



20141374



Хэрэглэгчийн Радио болон UTP холболтын төхөөрөмжийг хүлээлцсэн акт

Leased Line/ Economy/ VPN/ Бусад (доогуур зурах)

Хэрэглэгчийн нэр: НБХ (IPNC дээрх)

Шинэ  Түр  Нүүлгэсэн  Холболтын төрөл шилжсэн  Гэмтэл

Салбарын нэр: .....

Байршил: Аймаг/Хот: .....

Сум/Дүүрэг: .....

\*Холболтын төрөл шилжсэн бол: Хуучин холболт ..... Шинэ холболт ..... Түр холболт эзэх .....

№	Төхөөрөмжийн нэр	Төрөл	Сериал	Хэрэглэгчийн байрны		Тоо /м/	Тайлбар
				Дотор	Гадна		
1	Радио модем						
2	Power injector						
3	Радио модемны адаптер						
4	Антен						
5	Антену суурь						
6	Антен ба тохөөрөмжийн хоорондох кабель	Radio jumper cable	N/A				
7	Радио модемны хайрцаг						
8	STP кабель						
9	Аянга зайлуулагч						
10	Газардуулгын кабель						
11	STP CABLE					80	
12	RJ45 CAT5e					2	
13							
14							
15							
16							

\*Leased Line болон VPN үйлчилгээ авч байгаа бол хэрэглэгчийн IP хаягийн мэдээллийг заавал бөглөх

IP address: 202.21.118.202 Subnet: 255.255.255.255 Gateway: 202.21.118.201 Бусад: 202.131.232.130 : DNS1

202.131.232.4 : DNS2

\*Economy үйлчилгээ авч байгаа бол хэрэглэгчийн нэр, нууц үгийг заавал бөглөх

User Name: ..... Password: ..... Бусад: .....

- Гэрээ байгуулсан Харилцагч Хариуцсан Менежерийн нэр: .....
- Гэрээн дээрх сүлжээний хурд: ..... kbps
- Суурилуулалт хийсний дараах сүлжээний хурд: ..... kbps

Радио холболт хүлээн авах хүснэгт

№	Шаггуур үзүүлэлт	Нөхцөл (Доогуур зурна уу)		Шаггуур хангаагүй бол шалтгаан болон авсан арга хэмжээ
		Тийм	Үгүй	
1	Антен болон суурийг бэхлсэн бүх эрэг боолт бүрэн, суларч муудхааргүй чанга боогдсон эзэх	Тийм	Үгүй	
2	Антен байрлуулсан суурины дээд талд аянга зайлуулагч байрлуулан газардуулсан эзэх	Тийм	Үгүй	
3	Гаднаас хэрэглэгчийн байрдуу орсон STP кабелийг цонх, хаалга ноолж оруулсан эзэх зохиоорол авсан талаар тайлбар бичгэ үү	Тийм	Үгүй	
4	Радио модемоос хэрэглэгчийн байрдуу татсан STP кабелийг /стандартын дагуу/ швэрхэн татаж, хөдөлөөнгүй бэхлсэн эзэх	Тийм	Үгүй	
5	Хэрэглэгч Rack-тай эзэх (төхөөрөмжийн хайрцаг) Rack хананд бэхлэн эзэх бэхлэггүй бол тайлбар бичгэ үү	Тийм	Үгүй	
6	Бүх кабель дээр бирк буюу хаяг зүүсэн эзэх	Тийм	Үгүй	
7	Радио модем, power injector, router-ын wan port-руу орсон кабелийн толгой хэвийн (кабелийн утаснууд ил гараагүй, бүрээс бүтэн, толгойн түгжээ бүтэн) эзэх	Тийм	Үгүй	
8	Төхөөрөмжүүдийг тэгээлийн уртаагач болон тог баригчид ямар нэгэн хондирол үүсч салахгүйгээр найдвартай холбосон эзэх	Тийм	Үгүй	
9	Ping-ийн үр дүн үзсэн эзэх (дотоод, гадаад)	Тийм	Үгүй	Дотоод: ..... Гадаад: .....

\*\*\* Шаардлага хангахгүй, хэвийн бус зүйл үзлэгийн үеэр илэрвэл хэрэглэгчтэй хамтран асуудлыг газар дээр нь шийдвэрлэнэ.

Бусад тайлбар: .....



Хэрэглэгчийн холболт болон төхөөрөмжийг хүлээлцсэн;

Хэрэглэгчийн төлөөлж хүлээн авсан:

Нийлүүлэгчийн төлөөлж хүлээлцэн өгсөн:

/Нэр, Албан тушаал/

/Гарын үсэг/

/Нэр, Албан тушаал, хэргэс/

/Гарын үсэг/

2016 он 05 сар 01 өдөр



**\*Төхөөрөмжүүдийн ашиглалттай холбоотой анхаарах зүйлс:**

1. Төхөөрөмжүүдийг доор газар тавихгүй байх, зориулалтын хайрцганд (Rack) хийн байрлуулах
2. Сүлжээний төхөөрөмжүүдийг аль болох хүний хөлөөс хол байрлуулах
3. Тоос шороогүй цэвэр орчинд байрлуулах
4. Ус чийгнээс хол байлгах
5. Тэжээлийн найдвартай эх үүсвэрээр хангах (хүчдэлийн хэлбэлзлээс сэргийлэх), төхөөрөмж залгасан залгуураас хүчдэл их шаардах тоног төхөөрөмж залгахгүй байх
6. Дотор байрлуулах зориулалттай төхөөрөмжүүдийг тасалгааны тогтмол температуртай орчинд байрлуулах (0°C - 18°C температур)
7. Зуны цагт нарны шууд тусгалаас аль болох хол байрлуулах
8. Статик цэнэг үүсгэхээс зайлсхийх (хивс, дроз болон ноосон эдлэлтэй материалаас хол байлгах, цэнэг үүссэний дараа шууд төхөөрөмжүүдтэй харьцахаас зайлсхийх)
9. Гадна байрлуулсан төхөөрөмжүүдийн бүрэн бүтэн байдал, битүүмжлэл (ус чийгнээс сэргийлэх), бохирдлыг тогтмол шалгаж сэргийлэх

\*Дээрх 9 зүйлсийг дагаж мөрдөөгүйгээс үүдэн гарсан төхөөрөмжийн гэмтлийг нийлүүлэгч хариуцахгүй.

Тайлбар: Хэрэглэгч өөрийн байранд байрлуулсан төхөөрөмжүүдийг хэвийн ажиллагаатайгаар хүлээн авч хадгалалт, ажиллагааг хариуцах болсныг энэхүү актаар баталгаажуулж байна.

Хэрэглэгчийн санал хүсэлт, гомдол, лавлагааг ажлын өдрүүдэд 08:00-22:00 амралтын өдрүүдэд 08:00-20:00 цагийн хооронд дараах утсаар хүлээн авна.

Утас: 2222; 18002222  
Имэйл: [support@mobinet.mn](mailto:support@mobinet.mn)  
Веб: [www.mobinet.mn](http://www.mobinet.mn)

